



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/346

Зуунмод

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэн хугацааг сунгаж, авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6 “а”, “б”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоолын 1, 3, мөн 2021 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, 2021 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-ын 1 дүгээр хавсралт, 2021 оны 154 дүгээр тогтоолоор батлагдсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 171 дүгээр тушаалаар батлагдсан “Давтлага зохион байгуулах заавар батлах тухай” тушаалын 4, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Түр журам батлах тухай” тушаалын 2, 4, “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын 1.1, 2, 3, 6, 7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал сунгасугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2.1. Аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацаанд төрийн байгууллага, хуулийн этгээд, хүний үйл ажиллагааны зохицуулалтыг батлагдсан журамд заасны дагуу зохион байгуулж, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, халдварын тархалт нэмэгдсэн тохиолдолд тэмцэх хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), аймгийн Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар), сумын Засаг дарга нарт даалгасугай.

2.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтын ажлыг аймгийн хэмжээнд эрчимжүүлж, вакцинжуулалтад иргэдийг бүрэн хамруулах, бүх нийтийн дархлааг дэмжих ажлыг үе шаттай зохион байгуулж, иргэд олон нийтэд мэдээлж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.3 Бүртгэлийн цахим системийн QR код байршуулаагүй, үйлчлүүлсэн иргэдийг бүртгээгүй, халдвар хамгааллын дэглэм, холбогдох дүрэм журам мөрдөөгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т чиглэл болгосугай.

2101011017

2.4 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар (Р.Ундрахбаяр), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг) нарт даалгасугай.

2.5 “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-ын хэрэгжилтийг хангаж, хэсгийн хороо, санал авах байранд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллахыг аймаг, сумын сонгуулийн хороонд зөвлөж, халдвараас урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т даалгасугай.

2.6 Орон нутгийн орох, гарах чиглэлд байнгын ажиллагаатай хяналтын цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шаардлагатай тохиолдолд хяналтын түр цэгийг байгуулах, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга бөгөөд Онцгой комиссын орлогч (Н.Төмөрбаатар), Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/300 дугаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллах тухай”, мөн 2021 оны А/323 дугаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллах зарим арга хэмжээний тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР